



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/621

Алтай хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
дуудлага худалдааг дахин зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020 оны А/505 дугаар захирамжаар зарлагдсан “Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2015-2030 он”-д тусгагдсаны дагуу Алтай хотын инженерийн байгууламж бүхий бүс Шүтээний өндөрлөгийн хойд талд 3 нэгж талбарт газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг дахин зарлан явуулсугай.


2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэх газруудад архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж мөрдүүлэхийг аймгийн ерөнхий архитектор (Б.Бямбадорж)-т, дуудлага худалдааг 2020 оны 11 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ

Аймгийн Засаг даргын 2010 оны
11 дугаар сарын 09 ны өдрийн 4621 дугаар
захирамжийн хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ
ДУУДЛАГА ХУДАЛДАА ЗАРЛАН ГАЗРЫН БАЙРШИЛ, ЗОРИУЛАЛТ,
ХЭМЖЭЭ, ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ АНХНЫ ҮНЭ

№	Газрын байршил	Зориулалт	Талбайн хэмжээ /м2/	Дуудлага худалдааны анхны үнэ /мян.төг/
1	Жаргалант баг, Шүтээний өндөрлөгийн хойд талд	Худалдаа үйлчилгээний зориулалттай	2215	22150.0
2	Жаргалант баг, Шүтээний өндөрлөгийн хойд талд	Худалдаа үйлчилгээний зориулалттай	2215	22150.0
3	Жаргалант баг, Шүтээний өндөрлөгийн хойд талд	Худалдаа үйлчилгээний зориулалттай	643	6430.0

__оОо__